



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 654

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ┐  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даланзадгадын дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 1,490,186,390.06 (нэг тэрбум дөрвөн зуун ерэн сая нэг зуун наян зургаан мянга гурван зуун ерэн төгрөг зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 1,383,507,289.32 (нэг тэрбум гурван зуун наян гурван сая таван зуун долоон мянга хоёр зуун наян есөн төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Эрдэнэтөгс нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталж данснаас хасах хөрөнгөөс төмрийн хаягдлыг ялган тоолж худалдах, орлогыг компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006860  
33-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

"ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ  
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр                        | Ашиглалтад<br>орсон огноо | Тоо<br>хэмжээ                   | Хэмжих<br>нэгж | Нэг бүрийн үнэ<br>(төгрөг) | Балансын үнэ (төгрөг)                                                                                           | Хуриитлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                                           | Үлдэгдэл өртөг<br>(төгрөг)                                                                             |
|-----|--------------------------------------|---------------------------|---------------------------------|----------------|----------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Кат дизель станц                     | 2004.02.11                | 1                               | ком            | 281,949,168.80             | 281,949,168.80                                                                                                  | 281949168.8                                                                                                                 | 0                                                                                                      |
| 2   | 1-р контурын шугам<br>/Сувагжилтгүй/ | 2014.11.16                | 2739                            | м              | 441,123.48                 | 1,208,237,221.26                                                                                                | 1,101,558,120.52                                                                                                            | 106,679,100.7                                                                                          |
|     | Дүн                                  |                           | 2740                            |                | 282,390,292.28             | 1,490,186,390.06                                                                                                | 1,383,507,289.32                                                                                                            | 106,679,100.74                                                                                         |
|     | Нийт дүн                             |                           | (дөрвөн<br>зуун гучин<br>дөрөв) |                |                            | (нэг тэрбум дөрвөн<br>зуун ерэн сая нэг зуун<br>наян зургаан мянга<br>гурван зуун ерэн<br>төгрөг зургаан мөнгө) | (нэг тэрбум гурван<br>зуун наян гурван сая<br>таван зуун долоон<br>мянга хоёр зуун наян<br>есөн төгрөг гучин<br>хоёр мөнгө) | (нэг зуун зургаан<br>сая зургаан зуун<br>далан есөн мянга<br>нэг зуун төгрөг<br>далан дөрвөн<br>мөнгө) |